



НИЙСЛЭЛИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/37

Улаанбаатар хот

Ажил эрчимжүүлэх тухай

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргатай байгуулсан 2015 оны эхний хагас жилийн үр дүнгийн гэрээнд заасан гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлтийг нэмэгдүүлэх, улсын ерөнхий гүйцэтгэгчийн 2015 оны 01 тоот албан даалгавар, албаны даргын 2015 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/10 тоот тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эрчимжүүлж, бодит биелэлтийг нэмэгдүүлэх 90 хоногийн хугацаатай аяныг 2015 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 29-ны өдрийг дуустал хугацаанд зохион байгуулсугай.

2. Аяны хугацаанд гүйцэтгэх баримт бичиг нэг бүрт явуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эрчимжүүлж, бодит биелэлтийг нэмэгдүүлэн, улсын ерөнхий гүйцэтгэгчээс өгсөн албан даалгавар, албаны даргаас гаргасан тушаалд заасан үүргүүдийг нэг бүрчлэн биелүүлж, үр дүн гаргаж ажиллахыг нийт шийдвэр гүйцэтгэгч нарт үүрэг болгосугай.

3. Аяны хугацаанд хийх ажлын төлөвлөгөө гарган үр дүнтэй зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар өдөр тутам ханган хяналт тавьж ажиллахыг ахлах шийдвэр гүйцэтгэгч нарт үүрэг болгосугай.

4. Нийт албан хаагчдыг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллаж, дүнг 2015 оны 06 дугаар сарын 30-ны өдөр илтгэх хуудсаар танилцуулахыг дэд дарга /дэд хурандаа Ч.Оюунцэцэг/-т даалгасугай.

Тушаалыг албаны нийт бие бүрэлдэхүүнд танилцуулсугай.

ДАРГА, ХУРАНДАА

Т.ЭНХБАТ

112015000106
2015 tushaal